



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/321

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилттэй Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Л.Ганхуяг	-(Орон нутгийн өмчийн газрын дарга)
Гишүүд:	Л.Хаш-Эрдэнэ	-(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	М.Эрдэнэбилэг	-(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсоноор)
	Б.Галсанжамц	-(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичиг:	Г.Болор-Эрдэнэ	-(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Ганхуяг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ